



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 04 сарын 17 өдөр

Дугаар 051

Жавхлант

Мал, амьтны шимэгчтэх өвчөөс эмчлэн
сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Мал, амьтны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6, 21 дүгээр зүйлийн 21.1, 21.3, 21.3.1, 21.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал, амьтны шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх угаалга, туулгалт, боловсруулалтад хамруулах төлөвлөгөөт арга хэмжээг 2025 оны 04 дугаар сарын 01-ны өдрөөс 2025 оны 11 дүгээр сарын 01-ийг хүртэлх хугацаанд зохион байгуулж гүйцэтгэхийг “Түмэн сувд” хариуцлагатай хувьцаат компаний захирал (Ч.Амартүвшин), малын эмч (М.Орхонтуул), “Дэлгэрэх наран эрдэнэ” хариуцлагатай хувьцаат компаний захирал (Д.Жавзмаа), “Эх цаг” хариуцлагатай хувьцаат компаний захирал (Ч.Нацаг), “Бидний оролцоо зөв” хариуцлагатай хувьцаат компаний захирал (Д.Баяртуяа), нарт үүрэг болгосугай.

2. Мал эмнэлгийн арга хэмжээнд мал сүргээ бүрэн хамруулаагүй, хамруулахаас зайлсхийсэн малчин, мал бүхий иргэд, заавар журмыг баримтлаагүйн улмаас малын өвчин гарах нөхцөлийг бүрдүүлсэн албан тушаалтанд хуулийн дагуу хариуцлага тооцох, урьдчилан сэргийлэх арга хэмжээнд шаардлагатай вакцин, био бэлдмэл, эмийн бодис, урвалж, хамгаалах хувцас хэрэгсэл, мэргэжил арга зүйн заавар зөвлөмжөөр хангах, гүйцэтгэлийг хянан шалгаж, үр дүнг танилцуулахыг Мал эмнэлгийн тасгийн тархвар зүйч (Г.Шижирбаатар)-т үүрэг болгосугай.

3. Товолсон хугацаанд шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээнд малаа бүрэн хамруулахыг малчин, мал бүхий иргэдэд мэдэгдэж ажиллахыг багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын орлогч (Г.Энхзаяа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Ц.БАТЧУЛУУН

